

**ОРЧИН ҮЕИЙН ТӨВ АЗИЙН МАЛ АЖ АХУЙ:  
МАЛЫН ТУХАЙ АРДЫН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ**

М.Хурметхан\*

**Товч утга**

**Т**өв Азийн мал, мал аж ахуй, мал маллах арга технологи, ашиг шим болон орчин үеийн байдлыг тусган харуулсан.

**Түлхүүр үг:** Төв ази, мал аж ахуй, орчин үе

**Туркменистаны мал аж ахуй**

БНТуркменистан улс нь Дундад Азийн баруун өмнөд хэсэгт оршдог. Газар нутгийн хэмжээ 488.2 мянган км.кв. Хүн ам нь 4688963 /2007/. Хойд талаараа Казахстан, хойд болон зүүн талаараа Узбекистан, өмнөд талаараа Афганистан, Ирантай хил залган оршдог. Нутгийн ихэнх нь тал, 4/5 нь Тураны хонхорт оршдог. Хамгийн гол байгалийн баялаг нь газрын тос, байгалийн хий. Зун халуун, хуурай, өвөл дулаан, хавар их богино боловч бороо ихтэй, намар нь хуурай болдог онцлогтой. Нутгийн 80%-д газрын гадаргуун болон тогтмол урсгал ус үгүй. Туркменистан үндсэндээ каракуль хонийг өсгөдөг. 1976 онд Туркменистанд үхэр 531.6мян. толгой, гахай 121.7мян толгой, хонь ямаа 4423.3 мян толгой, 13.2 мян толгой адуу, 88.1 мян толгой тэмээ байв. Баян бүрдүүдэд мал аж ахуй сайн хөгжсөн байдаг.

Туркменистан тусгаар тогтнолоо зарласны дараа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн 1980-аад оныхоос буурав. Мал аж ахуйд каракуль хонь үржүүлэх, ямаа, адуу, тэмээ чухал үүрэгтэй. 1996 онд Туркменстанд 111.2 мян тонн мах, 754.8 тонн сүү үйлдвэрлэж, нэг хүнд 24.2кг мах /хэрэгцээ 42кг/, 164кг сүү /хэрэгцээ 185кг/ байв.

\*М.Хурметхан- Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Sc.D), профессор

1997 онд нийгмийн болон хувийн өмчид 1155.6 мян толгой үхэр, /1991онд 829мян толгой/, 6138.2мян толгой хонь ямаа /5477мян толгой/, 105.6 мян толгой тэмээ /86.7мян/ байв. Мал аж ахуйд хонин аж ахуй давамгайлж, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 70%-ийг дангаараа өгнө. Каракуль болон сараджин үүлдрийн хонь өсгөдөг. Сүүлийн 10 жилд хонины тоо 33% өсч, хонины мах 57%, арьс 22% нэмэгджээ.

### **Узбекистаны мал аж ахуй**

БНУзбекистан улсын газар нутгийн хэмжээ 447.1 мянган км.кв. Хүн ам нь 25 563 441 /2002/. Газар нутаг нь зүүн-баруун тал хээр, зүүн өмнөд уулархаг хэсэгт хуваагдана. Ховор металл, төмөр, алт зэрэг ашигт малтмал бий. Тэндээс 562 зүйл минерал олджээ. Газрын тос 5 муж нутагт илэрчээ. Узбекистаны мал аж ахуйд каракуль хонь чухал байр эзэлнэ. Бэлчээр ба хадлангийн талбай 21.5 сая га болно. 1974 онд үхэр 3181.7 мян. толгой /үүнээс үнээ 1216.4/, гахай 329.6, хонь ямаа 8539.1мян толгой байв. Каракуль хонийг Бухара мужид өсгөдөг. 2001 онд Узбекистанд 8.1 сая толгой хонь, 5.3сая толгой үхэр, 830000 толгой ямаа, 89000 толгой гахай, 165000 илжиг, 150000 адуу, 28000 тэмээ, 14 сая орчим тахиа байв. Мөн онд мах үйлдвэрлэл нийт 512000 тонн, түүнээм үхрийнх 77%, хониных 17% гэх мэт байв. 15900 тонн ноос өгчээ. Мөн хүр хорхой өсгөж, 2000 онд 1200 тонн торго үйлдвэрлэжээ.<sup>1</sup>

### **Афганистаны мал аж ахуй**

Афганистан Төв Азийн өмнөд хэсэгт оршдог. Өмнөд талаараа Пакистан, баруун талаараа Иран, зүүн талаараа Тажикстан, Узбекистантай, зүүн хойд талаараа БНХАУ-тай хиллэнэ. Газар нутгийн хэмжээ 647.5мя км.кв. хүн ам нь 27 755 775 /2002/. Газар нутгийн 3/4 нь уулархаг. Баруун хойт болон өмнөд хэсэг нь тал хээр. хуурай халуун цаг ууртай. Хур тунадасны хэмжээ 350-800мм. Газрын тос, байгалийн хий, нүүрс, төмрийн баялаг ихтэй орон. Уламжлалт мал аж ахуйн орон болно Афганистанд 4.8 сая толгой каракуль хонь үржүүлдэг бөгөөд бүх хонины тоо толгойн 1/4-ийг эзэлнэ. Гэхдээ сүүлийн 30 гаруй жилийн турш Афганистаны мал аж ахуйн талаар тодорхой статистик мэдээлэл үгүй юм. Мал аж ахуйд байгал цаг уурын хамт бусад шалтгааны хорогдол ч ихтэй. Энэ бүхний явцад хүн амын сүү махны хэрэгцээ хангагдахгүй байгаа юм. Нүүдлийн малчид голдуу хонь ямаа өсгөх бөгөөд барагцаалбал тэд махны 80%-ийг эзэмших бөгөөд 20сая толгой хонь, 3.3сая ямаатай гэж үздэг.

### Тажикстаны мал аж ахуй

Тажикстан улс Дундад Азийн өмнөд хэсэгт оршдог. Газар нутаг нь 143.1 мян км.кв. Хойд талаараа Узбекистан, Киргизстан, зүүн талаараа БНХАУ, өмнөд талаараа Афганистантай хил залгана. Хүн ам нь 6 719 567 /2002/.

Тажикстаны нутаг уулархаг байдаг. Нутгийн 93% нь Тянь-Шань, Гиссар Алай, Памирын уулсад байрлана. Нутгийн 1/2 нь далайн түвшингээс 3000м өндөрт оршино. Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Усны нөөцөөр баялаг орон юм. 1975 онд 1089.6 мян толгой үхэр, үүнээс 397.4 мян толгой үнээ, 2334.0 мян толгой хонь, 526.7 мян толгой ямаа, 41.4 мян толгой адуутай байв.

### Оросын Холбооны Улс

Европын дорнод хэсэг.

Нутаг дэвсгэр-17075.44

Хүн ам-148.6 сая /1993/

Нийслэл-Москва

Нутгийн Европын хэсэг нь талархаг, Уралын нуруунаас Саян, Байгалд өвөр Байгалийн уулс, Сибирийн тарамцаг уулстай. Далайн болон эх газрын эрс тэс, муссоны уур амьсгалын өөрчлөлттэй. 1-р сарын дундаж температур нь 1-50с, 7-р сарынх 1-25с, жилд 100-1000 мм хүртэл тундас унадаг. Нефть шатах хий, чулуун нүүрс, төмрийн хүдэр, үнэт, өнгөт төмөрлөг, фосфор, калийн давс, алмаз зэрэг олон төрлийн ашигт малтмал олборлодог. Том үйлдвэрүүд нь Москва, Санкт-Петербург, Унгар, Ижил мөрний сав газар, баруун Сибирьт төвлөрчээ. Машин, хими, нефть хими, хуванцар, эрдсийн бордоо, нийлэг мяндас, авто машины дугуй, барилгын материал, хөнгөн ба хүнсний үйлдвэртэй. Илчит, атомын болон УЦС-тай. Пуужин, сансрын хийгээд цөмийн техникийн салбар хөгжсөн. Үр тариа, чихрийн манжин, наранцэцэг, төмс, олсны ургамал голлон тарьдаг. Мах сүүний чиглэлийн үхэр, мах ноосны хонь өсгөдөг. ОХУ-ын малын бэлчээр нь 87.3 сая га бөгөөд нутгийн 5%-ийг эзэлнэ. ОХУ-д 2001 оны байдлаар үхэр-27 294 000, хонь-12 561 000, гахай-15 707 000, адуу -1.6 сая байв. Жилд 1.7 тэрбум ам долларын мах, махан бүтээгдэхүүн импортлоно.

*ОХУ-ын БНБуриад улс.*

Нутаг дэвсгэр-351.3 мянган кв.км /1989 оны байдлаар/

Хүн ам- 1045.6 мянган хүнтэй.

Нийслэл -Улаан Үд

Буриад улс нь Азийн төвд оршино. Өмнөд Сибирийн уулархаг нутагт хамрагдах бөгөөд дэлхийн цэнгэг усны нөөцийн үлэмж хэсгийг хамрах Байгаль нуур оршино. Байгаль нуур нь далайн түвшнээс 456 м өндөр өргөгджээ. Уулархаг газарт унах хур тунадас нь жилдээ 1000-1500мм хүрдэг боловч уулын хөндийд 180-300мм тунадас унадаг байна. Ургамлын нөмрийг нь уул тайга, мөн уул тайга нь хээртэй хосолсон бүс бий. Үүнээс гадна нуга хээрийн бүс ихээхэн талбай эзэлнэ. Ашигт малтмал арвин, ОХУ-ын цинкийн 48%, свинцийн 27% нь Буриад оронд байдаг. Усны нөөц арвин 34422 нуур цөөрөм байгаагаас усны нөөц бүхий Байгаль нуур нь Дэлхийн хамгийн цэнгэг устай нуур юм.

1996 оны байдлаар 4219.5 мянган га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байгаа нь нийт нутгийн 12.6% болно. Түүний дийлэнх нь бэлчээрийн эдэлбэр юм. Түүнээс гадна ойн талбай их. Нийт нутгийн 26361.0 мянган га буюу нийт нутгийн 75% нь ой мод юм. Ой болон бэлчээрийн эдэлбэрийг малын бэлчээрт ашиглах тул мал эсгэх бололцоо их. Ачийн тойрог болон Саяаны нуруу орчимд хагас нүүдлийн аж ахуйг эрхэлж байна. Харин нийт малаас үхэр зонхилох ба нүүдлийн мал аж ахуйг эрхэлж байсан үеийн нутгийн малыг одоо өсгөх сонирхолтой. Ер нь Буриад орон 1940 оноос хойш нүүдлийн мал аж ахуйгаас суурин мал аж ахуйд шилжсэн билээ. Дэлхийн 2-р дайны үед эрчүүд нь дайнд явснаас өвгөд, хөгшид, эмэгтэйчүүд нүүж чадахгүй малаа суурин хэлбэрээр өсгөх болсон байна. Одоо дийлэнх нь суурин хэлбэрийн мал аж ахуйг эрхэлж байна. Буриад улсын малын тоог 1916-2000 он хүртэл хүснэгтэнд үзүүлэв.

**ОХУ-ын Буриадын малын тоо (мянган толгой)**

Он	Үхэр	Үүнээс үнээ	Бог мал	Адуу
1916	411	196	394	-
1923	365	156	233	147
1941	414	160	530	140
1950	389	137	587	95
1960	370	137	1482	67
1970	440	160	1706	57
1980	502	175	1910	56
1990	560	180	1493	68
1994	455	177	822	73
1995	425	171	623	72

**Төв азийн мал аж ахуй: уламжлалт мэдлэг**

1996	397	162	455	68
1997	358	149	288	62
1998	347	147	294	57
1999	330	143	233	50
2000	355	150	254	51

XX –р зууны 90-ээд онд хөдөө аж ахуйн цаг агаарын тааламжгүй байдлын улмаас уналтад оров.1992-93 онд нийгмийн хэвшилд малын тоо 20%-иар хорогдсон байна<sup>2</sup>. Буриадын хөдөө аж ахуйд мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногоо давамгайлна. Мах үйлдвэрлэл 2005 онд 52.52 мян.т (2004 онд-50.11 мян.т) болов. Сүүний үйлдвэрлэл 225.92 мян.т (2004 онд 225.69 мян.т) болов.

*ОХУ-ын Тува улс:* Тува нь 175.5мян.км нутагтай. 310.0 мянган хүн амтай. Нийт хүн амын 67% нь Тува үндэстэн. Баруун, Төвийн район нь уулархаг, ойт хээрийн бүс давамгайлна. Нүүдлийн мал аж ахуй зонхилсон бог мал, үхэр зонхилсон. Ойролцоогоор нэг сая малтай. Бог мал зонхилсон болохоор нүүдлийн хэлбэрийг тэр мал л тодорхойлно. Зун цагт бүх мал бэлчээрт, харин өвлийн улиралд хашаа саравчинд малаа оруулж, хагас тэжээлийн хэлбэрээр маллана. Адуу мал аж ахуйд ихээхэн үүрэгтэй, түүний зэрэгцээ морин тэрэг, чаргыг ердийн хөсөгт өргөн ашиглана.

**1918-1944 оны хооронд Тувагийн ерөнхий дүр төрх дараах байдалтай байлаа.<sup>3</sup>**

	1918	1921	1931	1944
Бүх хүн ам.мян.хүн	60.6	63.0	82.2	95.0
Үүнээс тыва	48.0	50.0	64.9	80.8
Засаг захиргааны хошуу	5	7	-	15
Хот	1	1	1	1
Тосгон	-	30	-	108

**1921-1944 оны Тувагийн хөдөө аж ахуйн байдал<sup>4</sup>**

	1921	1931	1944
Тариалангийн бүх талбай мян.га	14	19.7	58.1
Үр тариа	-	18.6	-

**Малын тоо бүх аж ахуйн салбарт мян.тол**

Үхэр <sup>5</sup>	126	168.2	166.8
Гахай	1.2	1.3	2.5
Хонь,ямаа	631	821.6	609
Адуу	-	105.3	68.6
Буга	-	10.4	9.8

**Хөдөө аж ахуйн техник (нэгж)**

Трактор	-	9	42
Комбайн	-	-	2
Ачааны машин	-	-	11

**Тувагийн хүн ам**

Он	Бүх хүн ам мян. хүн	Уугуул тува	
		Мян.хүн	Хувь
1921	63	50	79.4
1931	82.2	64.9	78.9
1945	95.4	81.8	85.7
1959	171.9	98	57
1970	230.9	135.2	58.6
1979	267.6	161.9	60.5
1989	308.5	198.4	69.3
2000	310.9	208.6	67.1

Үүнээс үзэхэд уугуул хүн ам нь өнгөрсөн зуунд 50.0-208.6 мянга болсон нь харагдана. 2000 оны эхний байдлаар бүх хүн ам нь 310.9 мян.хүн байсан ба эрэгтэй 48.9%, эмэгтэй 51.1% байв. Эдийн засгийн салбарт ажиллагсдын дунд хөдөөд аж ахуйн салбарт ажиллагсад 16.9%-ийг эзэлж байв.

**Тувагийн аж ахуйн бүх салбарын малын тоо (жилийн эцэс,мян.тол)** <sup>5</sup>

	1945	1950	1960	1970	1980	1990	2000
Үхэр	143.9	102.8	137.6	194.1	161.2	205	97.2
Үнээ	64.1	46.3	54	72	61.1	73.9	45.7
Гахай	2.4	4.2	26	27.2	40.3	65.2	10.9
Хонь,ямаа	538.5	413.1	873.4	1119	1117.6	1226.8	653
Адуу	61.6	49.5	42.3	38.5	28.1	39.6	25.1
Буга	8.1	3.1	5.8	11.6	14.5	8.1	1.2

Эндээс харагдаж байгаачлан малын тоо толгой 1990-2000 онд хорогдсон байдал ажиглагдаж байна. Мөн нэг малаас авах ашиг шимийн хэмжээ мөн буурчээ. Тухайлбал 1990 онд хөдөө аж ахуйн бүх салбарт 23.6 мян тонн мах (нядалгааны жин) бэлтгэж байсан бол 2000 онд 12.3 мян.тонн болжээ<sup>6</sup>. Сүү 1990 онд 73.4 мян.т байснаа 47.0 мян.т , ноос 2328 т байснаа 750 т болж тус тус буурчээ.

1990 оноос хойш улс төр, эдийн засгийн өөрчлөлт, ялангуяа эдийн засаг, зах зээлийн харилцаанд шилжсэн, өмч хувьчлал, үнэ чөлөөлсөн, өмчийн олон хэлбэр үүссэн олон хүчин зүйлийн улмаас Тувагийн эдийн засаг бүхэлдээ уналтанд орж, бүх салбарын үйлдвэрлэл эрс буурч, ард түмний аж байдлын үзүүлэлтүүд ихэд буурчээ. Харин 1999 оноос эдийн засаг сэргэн хөгжих замд орж эхэлсэн юм. Тувад өмчийн янз бүрийн хэлбэрийн 246 үйлдвэр аж ахуйн газар, түүний дотор 43 том, дунд үйлдвэр ажиллаж байна. 2000 онд 830.2 сая рублийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 53.8%-ийг нь хувийн сектор эзэлж байв. Аж үйлдвэрийн голлох салбар бол түлш, эрчим хүч /нүүрс олборлох/, өнгөт металлурги /алт олборлолт/, ойн болон мод боловсруулах үйлдвэр, хөнгөн, хүнс, гурил, холимог тэжээлийн үйлдвэр хамаарна. Тувагийн томоохон үйлдвэрийн газрууд бол Каа Хэмийн нүүрсний ил уурхай, Тувагийн нэхий, хивсний комбинат, алтны олборлох артелиуд, оёдлын фабрик, Туваасбест комбинат, Ак-Довуракийн оёдол нэхмэлийн үйлдвэр юм. 2000 онд Тувагийн аж үйлдвэр нүүрс 522 мян.т, алт – 1143 кг, асбест – 2200 т, зүсмэл материал 8000 куб.м, гурил - 5000т, талх, талхан бүтээгдэхүүн 27мян.т тус тус үйлдвэрлэжээ.

Тувагийн эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй бөгөөд 2000 онд 1300 сая (үүнээс мал аж ахуй 938.7сая) рублийн

бүтээгдэхүүн гаргасны 89%-ийг иргэд болон хувийн аж ахуйнууд үйлдвэрлэжээ. Түүнд 27.6 мянган хувь буюу хөдөлмөрийн насны хүн амын 20 гаруй хувь ажилладаг. Өмч хувьчлал, газрын шинэтгэл явуулсны үр дүнд ардын аж ахуйтнууд олноор буй болж, эдийн засаг, ялангуяа ХАА-н үйлдвэрлэлд эерэг нөлөө үзүүлэх боллоо.

2001 оны 1-р сарын 1-ний байдлаар тус улс 96.4 мянган үхэр, түүнээс 45.7 мянган үнээ, 10.8 мянган гахай, 651.1 мянган толгой хонь, ямаа, 25 мянган адуу, 1.1 мянган буга, 130 мянган шувуу, 270 тэмээтэй байв.

2000 онд 12.3 мян.тонн мах, 47 мян.тонн сүү, 6.5 сая ш өндөг, 750 тонн ноос үйлдвэрлэжээ. Мөн онд 44.2 мян.га-д тариалалт хийснээс 29.4 мян.га-д үр тариа тариалж, үр тариа 24.9 мян.тонн, төмс 26.6 мян.тонн, хүнсний ногоо 5.4 мян.тонн хураан авчээ. ОХУ-ын Алтайн БНУ. Алтай нь 11 засаг захиргааны нэгж, 90 хөдөөгийн засаг захиргааг нэгтгэнэ. Газар нутаг нь 92 902 кв.км.бөгөөд ОХУ-ын бүх нутгийн 0.55 % нь болно. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар нь 19%, ой мод 47% юм. Нийслэл нь Горно-Алтайск хот. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь 2001 онд 1871.3 сая рубль хүрчээ. Хөдөө аж ахуйн бүтцэд мал аж ахуй нь 70%, тариалан 30%-ийг эзэлнэ. Мал аж ахуй нь бэлчээрийнх бөгөөд өвөрмөц бүтээгдэхүүн өгнө.

Үүнд: -марал бугын аж ахуй нь гадаад валютын гол эх үүсвэр болно

- уулын-Алтай үүлдрийн ямааны ноолуур
- бэлчээрийн адууны аж ахуй
- зөгийн аж ахуй зэрэг болно.

### **БНХАУ-ын Төв Азийн сектор**

БНХАУ-ын байгалийн бүс нь ихээхэн ялгагдах орны нэг юм. Тус орон байгалийн 9 бүсэд хуваагдана. 9.6 сая хавтгай дөрвөлжин км нутаг нь энэ орныг дэлхийн хэмжээнд Орос, Канадын дараах байранд оруулжээ. БНХАУ-ын нутаг нь өргөн уудам тул далайн эргийн зөөлөн уур амьсгалын зэрэгцээгээр нүүдлийн мал аж ахуй эрхлэх 5 томоохон район байдаг. Эдгээр районд дэлхийн нүүдлийн мал аж ахуйд тэргүүн байранд ордог олон зүйл байдаг тул юуны өмнө эдгээр 5 районы байгаль цаг уурын байдалтай товч танилцана.

Малын байгалийн бэлчээр нь 3.53 сая км<sup>2</sup> бөгөөд бүх Хятадын нутгийн 37%-ийг эзэлнэ. Мал аж ахуйн том нутаг бол Синьзян, Ганьсу, Цинхай, Өвөр Монгол болно. 1976-1980 онд бэлчээрийг 303 сая га өргөжүүлэв. Байгалийн олон янзын бүс бүслүүр нь



нүүдлийн мал аж ахуй уламжлан хөгжиж ирсэн түүхийг 70 гаруй сая га бэлчээр, хадлангийн талбай байдаг нь малын тэжээлийн баазын үндэс болж байгаа юм. БНХАУ-ын ХААЯ-аас 10 чухал арга хэмжээ авч явуулж байгаагийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах асуудал юм. Энэ нь нүүдлийн мал аж ахуйн уламжлалт районуудад ихээхэн тусгалаа олж байна. Үүнд : Умардын байгалийн бэлчээрийн нөөцийг хамгаалах бүс, Хөх мөрний дээд урсгал болж Хатан голын дунд , дээд урсгалын бэлчээрийг хамгаалах бүс, Хөх нуур, Төвдийн өндөрлөгийн байгалийн бэлчээрийг хамгаалах бүс, Баруун өмнөд нутгийн бэлчээрийг хамгаалан зохистой ашиглах бүс зэрэг 4 төрлийн бүсийг сэргээн байгуулах зорилт тавин ажиллаж байна.

БНХАУ-д хонь 1952 онд 36.9 сая байсан бол 2000 онд 133.2 саяд хүрэв. Хонийг Сяньзын, Өвөр Монгол, Ганьсу дахь хятад биш үндэстнүүд үржүүлнэ. Ямааг сүү болон ноолуурын ашиг шимийн хувьд өсгөж, 1952 онд 24.9 сая байсан бол 2001 онд 157.4 сая хүрэв. Хонь болон ямааны тоо толгой 2001 онд 288 саяд хүрэв. 2001 онд 129 сая толгой үхэр /1965 онд 66.6 сая байсан/ ба сарлаг байсан ба адуу 1965 онд 792 000 байсанаас 8.8 сая толгойд хүрэв. 2001 онд БНХАУ 65.3 сая тонн мах үйлдвэрлэсэн нь дэлхийн мах үйлдвэрлэлийн 27%-ийг дангаараа эзэлж байлаа.

*Өвөр Монголын Өөртөө Засах Орны мал аж ахуй.* ӨМӨЗО нь нийт Хятад орны 12%-ийг эзлэх цөл, цөлөрхөг хээр, тал, Хянганы уулархаг нутаг зэрэг байгалийн олон бүсийг хамарсан нутагтай. БНХАУ-ын хэмжээнд 2-р байранд орох Шар мөрөн буюу Хатан голоос эхлээд Эржин, Лиан, Нэнжин зэрэг олон том гол мөрөнтэй. Уур амьсгалын хувьд эх газрын болон зөөлөн цаг уурын аль нь ч бий. Жилд 50-500 мм хур тунадас унах нутаг байхын зэрэгцээ Хянганы уулсын орчим түүнээс ч их хур тунадас унана. Ойн талбай нь бүх Хятадын нийт ойн 13.6%-ийг эзэлнэ. Ойн зах нутаг нь малын бэлчээрт ашиглахад тохиромжтой. Ер нь ӨМӨЗО нь бэлчээр нутгаар арвин юм. 8.8 сая га бэлчээр нь 2000 км урт зурвасыг хамрах бөгөөд БНХАУ-ын бэлчээрийн томоохон эзэмшил районд багтдаг байна. Бэлчээр нь олон мянган км урт үргэлжлэх тул байгал цаг уурын олон бүсийг төлөөлдөг. Энд ойт хээр, хээр, цөлөрхөг хээр, заримдаа цөл, цөлийн бэлчээр аль аль нь бий. Байгалийн бэлчээрийн арвин нөөц нь Шанхын үхэр, адуу, үзэмчин хонь, мухар улаан үхэр, алшаа үхэр, ноолуурын цагаан ямаа зэрэг олон үүлдрийн мал өсгөх таатай нөхцлийг бүрдүүлжээ. ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн Линьхэ хотын цагаан ямааны ноолуур нь ширхэг

урт, өнгөлөг, бат бэх, уян хатан чанар сайн тул Итали улсад болдог олон улсын үзэсгэлэнгээс алтан медаль хүртэж байжээ. Зөвхөн Баяннуур аймгийн Линьхэ хотын орчимд 10 сая хонь, ямаа өсгөж 5 саяыг нь хэрэглээнд оруулж байна. Линьхэ хот ойрын жилүүдэд сайн үүлдрийн хонь ямааг сүргийн бүтцэд 80%-д хүргэж, нэг хонь ямааны нядалгааны цэвэр жинг 20 кг-д хүргэх ноолуурын хэмжээг 300гр-д хүргэх зорилттой ажиллаж байна.

Өвөр Монголд эрт цагаас нааш суурин суусан монголчууд мал аж ахуйг эрхэлж иржээ. 1947-1957 оны хооронд мал аж ахуйн салбарт ахиц гарчээ. "Гурван улаан тугийн" нөлөө хүндээр тусчээ. ӨМӨЗО-нд 2000 гаруй мал аж үйлдвэрийн хоршоог 152 коммун болгожээ. "Соёлын хувьсгал" нь уугуул оршин суугчдын амьдрал, эдийн засагт ихээхэн хор хөнөөл учруулав. 1947-1954 онд 1.9 сая , 1957-1967 онд 5.5 сая , 1967-1977 онд 4.6 сая мал хорогджээ. 1952-1978 оны хооронд жил бүр дунджаар 2.5 сая мал хорогдож, жилийн хорогдлын дундаж нь нийт малын 7%-иас давж байжээ.

1978 онд болсон ХКН-ын 11 дэх удаагийн III бүгд хурлаас хойш Өвөр Монголын мал аж ахуйд ч бодит өөрчлөлт гарав. 1950 онд 26 сая хоньтой байсан бол 1950-1965 оны хооронд малын тоо ойролцоогоор 70 сая (1965 онд 69 сая) болж, 2.65 дахин өсчээ. 1965-2000 оны хоорондох 35 жилд малын нийт тоо толгой 70 сая орчимд хэлбэлзэж байна<sup>7</sup>. XX-р зууны 90-ээд онд ӨМӨЗО-ны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гуравны нэгийг мал аж ахуйн салбар гаргаж байжээ. 1990 оны тоо бүртгэлийн мэдээгээр 48 сая малтай байжээ<sup>8</sup>. Хонь 20 сая гаруй, ямаа 8 сая гаруй, үхэр 4 сая шахам, адуу 2 сая гаруй, тэмээ 231 мянга гаруй, нийтдээ 36 сая малтай гэж зарим хүмүүс тэмдэглэжээ. Харин 1992 онд ӨМӨЗО-ны мал аж ахуй 55.5 саяд хүрсэн гэсэн мэдээнд гахай, илжиг, луус, цаа буга ч малын тоонд орсон ажээ.

Малын 56-58% нь Ордосын өндөрлөгийн хойт болон баруун хэсэгт, тухайлбал Хөлөнбуйр, Шилийн гол, Улаанцав, Баяннуур, Алшаа зэрэг бэлчээрийн мал аж ахуй дагнан эрхэлж буй нутагт 42-44% нь газар тариалан эрхэлсэн Хянган аймаг, Ноон мөрний сав, Их хянганы хотгор, Жирэм аймгийн гол мөрний эрэг орчим, Улаанцав аймгийн гол устай элсэрхэг нутаг, мал, ойн аж ахуй хослон эрхэлдэг Их хянганы нуруу, Хэлань, Майхан уулын бүс нутаг, Шар мөрний эрэг хавийн 8 хошуу, газар тариалан, мал аж ахуй голлон эрхэлдэг Их хянганы нуруу, Түмэдийн тал, Баруун ляо голын сав, Ноон мөрний эрэг орчим байна. Ашиглаж болох бэлчээрийн талбай 66.6 сая га, бэлчээрийг тэжээлийн нөөц нь 133.6 сая тонн бөгөөд хонин

толгойд шилжүүлснээр 93.4 сая малд хүрэлцэнэ. Өвөл, хаврын бэлчээр нь 52.2 сая га, гэжээлийн нөөц 39.6 тонн, нэг хонь өдөрт 5кг өвс иднэ гэж үзвэл бэлчээрийн талбай нь 23.6 сая (1991оны мэдээгээр-54.7 саяд) малд хүрэлцэнэ<sup>9</sup>.

1979 онд мал аж ахуй эрхэлж буй 332 мянган өрх, 1 сая 739 мянган хүнээс хөдөлмөрийн чадвартай нь 545 мянган хүн байжээ. 1988 оны байдлаар 400 мян.өрх 1сая 900 мянган хүнээс хөдөлмөрийн чадвартай нь 795 мян байжээ. Мал аж ахуй эрхэлдэг бүс нутагт буй нийт хүн амын 90% нь ӨМӨЗО-ны уугуул хүн ам болох малчин монголчууд болон бусад цөөн тоот үндэстний төлөөлөгчид юм. Өвөр монголын малчид гол төлөв хагас суурин хэлбэрээр ашиглаж, зуслан, намаржаа, өвөл-хаваржаа гэсэн гурван сууринд суурьшина. Мал аж ахуйн зохион байгуулалтын хэлбэр нь мөн л хот айл бөгөөд байгал, цаг уур, малын тоо, даац гэх мэт хамааран хот айлд байх өрх, мал сүргийн тоо, бүтэц харилцан адилгүй юм. Нэг суурь нь 200-1000 толгой хонь, 50-500 орчим бодтой байна. 1990-ээд оны эхэн хүртэлх 40 жилд ӨМ мал аж ахуйн салбар дотоодын хэрэгцээг оруулахгүйгээр БНХАУ-д 69.1 сая хонь, 6.7 сая үхэр, 4.1 сая адуу, 22.7 сая гахай, 1 сая 146 мян.тонн сүү, 945 мян. тонн ноос ноолуур, 150 сая бод богийн арьс буюу үнийн дүнгээр нийтдээ 138.5 миллиард юанийн бүтээгдэхүүн нийлүүлжээ<sup>10</sup>.

XX-р зууны 80-аад онд мал аж ахуйг шинэчлэх олон арга хэмжээг авчээ. ӨМӨЗО-ны бүх малын 95%, нутаг бэлчээрийн гуравны хоёр хувь нь өрхийн аж ахуйд шилжсэн байна<sup>11</sup>.

1986-1990 онд малын тоо 42.5 сая /гахай орно/, VI таван жилийнхээс 3.7 сая буюу 2.8% нэмэгджээ. Төлийн хорогдол өмнөх таван жилд 5.8% байсан бол 4.3% болжээ. Сайн үүлдрийн болон үүлдэр сайжруулсан бод, бог мал жил бүр 9.4%-иар өсч, 22 сая болж, нийт малын 46.3%-д хүрчээ. Улсын хэрэгцээнд жил бүр 9.3 сая толгой мал нийлүүлжээ. 53.3 мян.тонн хонины ноос, 1800 тонн ямааны ноолуур бэлтгэжээ. ӨМӨЗО-ныхун ам тутамд жилд дунджаар 2016 кг мах, 15.2 кг сүү оногджээ. 1989 оны байдлаар хашаа барьж, хашааны бэлчээрийн талбай 2 сая 800 мян.га, таримал бэлчээр 1 сая 490 мянга, сайжруулсан бэлчээр 1сая 510 саяд хүрчээ. Бэлчээр хамгаалах тарьсан ойн зурвасын нийт талбай 70 сая га болжээ. ӨМ-д 3 сая 890 мян. өвөл-хаврын өтөг бууц бүхий хороотой. Түүний 3 сая 750 мян нь тохилог дулаан саравчтай болжээ. Нийт малын 80% нь өвөл- хаврын дулаан хашаа хороогоор хангагджээ. Мал аж ахуйн салбарыг механикжуулах ажилд ахиц гарчээ. 1990 оны байдлаар мал аж ахуй эрхэлж буй бүс нутагт жижиг оврын

трактор 32970, өвс таригч, хаман боогч машин 19 мян, ус татах төхөөрөмж 24500, тээж боловсруулах жижиг оврын машин 47500 байгаа нь 1978 оныхоос 4 дахин их болжээ. 1992 оны байдлаар 400 мян. айл өрхийн 95 мян нь нар, салхины хүчээр ажилладаг бага оврын цахилгаан гаргагч мотортой болжээ. Дэд бүтцийн хөгжилтэй уялдан малчдын амьдралд мэдэгдэхүйц өөрчлөлт гарав. Идэж уух, өмсөж зүүх, эдэлж хэрэглэх, орон сууцны нөхцөл дээшилжээ. Мах сүү, цагаан идээ, ногоо, жимс, ургамлын тос зэргийг өргөн хэрэглэж байна. 1990 оны байдлаар малчдын 80% нь өвөлжөөндөө тоосгон байшин барьж, 100 өрхийн 51% нь зурагттай, 9.1% нь оёдлын машинтай, 61.2% нь дуу хураагчтай болжээ. 1991-1995 онд малын тоог 56.7 саяд хүргэн, 1990 оныхоос 6.8% өсгөх, нийт малын 55%-ийг сайн үүлдэр болон сайжруулсан үүлдрийн мал болгох, мах-680 мян.т, хонины ноос 71 мян.т, ямааны ноолуур 2400 т, сүү 550 мян. т тус тус үйлдвэрлэхээр төлөвлөж байв. Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нийт хэмжээг 280 сая юань, малчдын цэвэр орлогыг 1300 юань, 2000 онд малын тоо толгойг 60 саяд, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 360 сая юаньд, малчдын цэвэр орлогыг 1600 юаньд т ус тус хүргэх зорилт тавьж байлаа. 2006 онд мах үйлдвэрлэл 2,5 сая тн, гахайн мах-948 мян.тн, үхрийн мах-381 мян. тн, хонины мах-847 мян.тн, ноолуур-6792 тн, хонины ноос-98 мян. тн. байжээ. Бод малын тоо- 10 сая, бог малын тоо-89 сая, гахай -10 сая байв<sup>12</sup>.

Өнөөгийн байдлаар 86.667 сая га бэлчээрийн талбай, түүнээс 68.18 сая га-г ашиглах бололцоотой. 1990 оны байдлаар доройтсон бэлчээрийн хэмжээ 29.92 сая га болж, ашиглаж болохуйц бэлчээрийн нийт талбайн 44%-д хүрчээ. Цөлжилтөд 695 мян.км<sup>2</sup> (22.97%) хөрсний элэгдэлд оржээ. 1960-аад онд 5261 км<sup>2</sup> байсан усан талбай 80-аад онд 3940 км<sup>2</sup> болж 1321 км<sup>2</sup> -аар багасчээ. 300 км<sup>2</sup> байсан Алашаа аймгийн Гашуун нуур 1992 онд ширгэжээ. Энэ нь 2000 онд хүн ам нь 18.82 сая болж, 79.24%-ийг Хятад хүмүүс эзэлж, монголчууд 4.03 сая, нийт хүн амын 16.96% нь болжээ<sup>13</sup>. 2006 онд хүн ам нь 23,923,500 болж, монголчууд 4.2 сая болжээ. Хятад хүмүүс ихээр суурьшин газар хагалж, эмийн өвс түүх зэргээр ургамлыг сүйтгэсэн нь бэлчээрийг доройтуулах том шалтгаан болжээ. Малын бэлчээрийг сэргээн сайжруулах хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

*Синьзян-Уйгурын Өөртөө Засах Орон:* Синьзян-Уйгурын Өөртөө Засах Орон нь 1.66 сая км нутаг дэвсгэртэй. Энэ нь бүх Хятадын нутгийн 16.6%-ийг эзлэх бөгөөд Казахстан, Монгол,

Орос, Киргизстан, Афганистан, Тажикстан, Энэтхэг зэрэг 8 улстай хиллэж өөрийн орны дотор хэд хэдэн мужтай зэрэгцэн оршино. Хилийн шугам нь 5400 гаруй км байдаг нь бүх Хятадын хилийн шугамын 25% болох тул Хятаддаа хилийн шугамаар хамгийн урт, мөн гадаад орнуудтай нэвтрэх хилийн районтай. 17.7 сая хүнтэй, олон үндэстэн, ястантай. Далай тэнгисээс алс зайдуу эх газрын хуурай уур амьсгалтай. Энэ мужийн хойт хэсэг нь Алтайн нуруу, Алтан уулс сүндэрлэж, дунд талаар нь Тэнгэр уул, оршиж Хятадын аялал жуулчлалын нөөц ихтэй томоохон бааз нутаг болдог. Өнгөт, ховор металл, алт, зэс, Лоб нуур, калит давсны нөөц их байдаг. Дэлхийд нэрд гарсан “Торгоны зам”-ын үлэмж хэсэг нь Сяньзян-Уйгурын нутгийг дайран гардаг байна. СУӨЗО-ны Урумчи, Ками орчмын бусад хойд хагасын нутагт хонь, ямаа, үхэр, тэмээ, адуу голлосон мал аж ахуй эрхэлнэ. СУАР нь БНХАУ-ын мал аж ахуйн таван районы нэг бөгөөд нийт малын 10% нь энд байрладаг. Малыг жилийн дөрвөн улиралд бэлчээрээр малладаг учир байгалийн бэрхшээлтэй тулгардаг. Тус районд 45 сая га талбай малын бэлчээртэй бөгөөд шинээр бэлчээр нэмж ашиглаж байна.

СУАР-ын мал аж ахуйн 1943-1985 оны байдлыг тоймлон үзүүлбэл <sup>14</sup>:

Он	Мал
1943	14.430.000
1949	12.000.000
1953	15.430.000
1954	17.100.000
1957	20.460.000

Синьзяны хэвлэлд малын тоо толгой /мян.тол/-1955 онд 4 029, 1965 онд 4 633,6 1978 онд 4 461,9 ,1998 онд 41 500 болсон гэжээ<sup>15</sup>.

СУАР-ын статистикийн төвөөс гаргасан мэдээгээр 1983 онд Синьзяны малын тоо 35 сая 950 мянга гаруй толгойд хүрсэн байлаа. Малын 75 орчим хувь нь хонь, ямаа бөгөөд хонины тоогоор Хятадад Өвөр Монголын дараа орно. Тус районд 1 сая илжиг, 160 мянган сарлаг байна.

Синьзянд Хятадуудыг олноор нүүлгэн ирүүлж суурьшуулахтай холбогдон малын бэлчээрийг их хэмжээгээр хагалж байгаа нь тус автономит районы эдийн засгийн бэрхшээлт байдлыг гүнзгийрүүлэх, Хятад биш ард түмний хүн амын амьдрал доройтоход хүргэсэн

байна. 1950 онд Синьзяны эдийн засгийн үндэс нь хөдөө аж ахуй байсан бөгөөд түүнд хүн амын 86%, газар тариаланд 75%, (уйгур, хотон) мал аж ахуйд 11% (казах, монгол) ажиллаж байв. 1950 оны эхний хагаст мал аж ахуйг өсгөх талаар ажлууд хийгдэв. 1955 онд эдийн засгийн бололцоог харгалзахгүйгээр хөдөө аж ахуйд өөрчлөлт хийж, хамтралжуулав. 1958 онд 85 мянга орчим өрх буюу районы нийт хүн амын 76%-ийг нэгтгэсэн мал аж ахуйн 1716 хоршооллыг байгуулжээ<sup>16</sup>. Мал аж ахуй дахь “өөрчлөлт” нь “их үсрэлт”, “коммунчлах” явдлаар үргэлжилжээ. 1959 онд малын тоо толгойг 50 саяд хүргэхээр төлөвлөж байв. Гэвч 1960 оноос хойшхи үйл явдлууд энэ төлөвлөгөөг биелүүлэх бололцоо өгөөгүй байна. “Соёлын хувьсгал” нь СУАР-ын мал аж ахуйд ч сөрөг нөлөө үзүүлсэн байлаа.

Мал аж ахуйд оруулсан хөрөнгө бага байсан байсан нь хүндээр тусч байв. СУАР-д 1950-1979 оны хоорондох 29 жилд үхсэн мал 62.5 сая байгаа ба улсаас мөн хугацаанд худалдан авсан малын нийт тоо үүнээс 15.5 сая илүү байна гэж “Миньзуяньзю” сэтгүүлд тэмдэглэжээ<sup>17</sup>. 1980-аад оны дундаас хойш СУАР-ын мал аж ахуйд нааштай өөрчлөлтүүд гарч эхэлжээ. Тухайлбал, 1994 он гэхэд СУАР-ын нийт малын тоо 35.5 сая толгойд хүрэв<sup>18</sup>. 1994 оны хавар гэхэд 14 сая 839 мян.төл хүлээн авч, бүгд 43 сая 666 мянга 300 толгой мал өсгөж байлаа. 1994 онд мах үйлдвэрлэл 410 мян.т, сүүний үйлдвэрлэл 420 мян.т болжээ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ 27 тэрбум 750 сая юаньд хүрчээ<sup>19</sup>. 2008 оны эцсээр Синьзянд 47.4 сая толгой мал байсан нь түрүү жилийнхээс 5,5% буурсан байжээ. Махны нийт үйлдвэрлэлийн хэмжээ 1,754,900 тн болж, 9,3% болж өсчээ. Үнээний сүү 2,090,600 тн болж, 6,5% өсчээ.<sup>20</sup> Мал аж ахуйд бэлчээр, тэжээл хүрэлцэхгүй байх, усаар гачигдах, малын өвчин, бэлчээрийн доройтол, цөлжилт, цахилгаан эрчим хүчээр хангах зэрэг салбарт тодорхой бэрхшээлүүд байсаар байна. Энд тэжээлийн баазыг өргөтгөх, бэлчээрийг хаших, тэжээлийн үйлдвэр байгуулах, салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах, худаг гаргах (1979 онд 33 мян худаг байв) ажлууд хийгдэж байна.

*Төвдийн Өөртөө Засах Орон.* Төвдийн өөртөө засах орон 12 сая.км нутаг дэвсгэртэй, 2 сая хүн амтай, засаг захиргааны төв Лхас хот. Төвд улс VII зуунд үүсч, XIII-XIV зуунд далай лам улс орны иргэний ба шашны тэргүүн болсон. XVIII зуунаас далай ламын засгийн эрхийг хэвээр үлдээж, манж чин улсын бүрэлдэхүүнд оржээ. Хималай, Каракорум, Кунь-Лунь, Син Төвдийн уулсаар

хязгаарладаг. 4.5 мян.м өндөр, тэгш өндөрлөг, толгодлог тал газар ба 6-7000 м өндөр уул нурууд хосолсон байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Тангла, Кайлас гэх мэт нуурууд, мөсөн голтой. Намцо, Селлинг, Данграом гэх мэт олон нууртай. Хайргархаг тэгш өндөрлөг, цөл, заримдаг цөл зонхилдог, голын олон хөндийгөөр тугайн ойтой. Уул нутгийг бэлчээрт голдуу ашигладаг. Хүн амын 48.6% нь Төвд үндэстэн. 1997 оны байдлаар ДНБ нь 7.698 сая хүрсэн бөгөөд үүний 70% нь хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбараас орсон байна. Боловсролын салбарт 4 их сургууль, 106 дунд сургуулийн зэрэгцээ, хувийн 806 сургууль ажиллаж байна.

Төвдийн өөртөө засах орон бол БНХАУ-ын мал аж ахуй эрхэлдэг таван районы нэг нь юм. Байгалийн бэлчээрийн нийт хэмжээ нь 82.052 сая га буюу улсын бүх бэлчээрийн 23%-ийг эзэлнэ. 2001 онд Төвдөд 150000 т мах, 200.000 т сүү үйлдвэрлэж, нэг хүнд 57 кг мах, 78 кг сүү ноогдсон нь дэлхийн дундаж төвшнөөс илүү байжээ. Төвдөд сарлаг, хайнаг, үхэр, адуу, илжиг, хонь, гахай үржүүлдэг. Мал аж ахуйн бүтээгдэхүүн нь Төвд хүмүүсийн амь зуулгын үндэс, хөнгөн аж үйлдвэрийн гол материал болно. Эдгээр нь Төвдийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэжээ. Төвдүүд эрт дээр үеэс мал аж ахуй эрхэлсээр иржээ. Гэвч мал аж ахуй эрхлэх эгэл болхи нүүдлийн аж төрөх ёс нь 1950-иад он хүртэл хэвээр байв. Үйлдвэрлэх хүчин нь доод түвшинд байлаа. Тоо бүртгэлийн мэдээгээр 1952 онд малын тоо толгой нь зөвхөн 9.74 сая байжээ. Өнгөрсөн хугацаанд Төвдийн мал аж ахуйд тодорхой бэрхшээлүүд гарсаар ирсэн боловч нилээд ахиц гарчээ. Үүнд: шинэ бэлчээр эзэмшиж, малыг ус тэжээлээр хангах, өвчнөөс сэргийлэх зэрэг арга хэмжээ авчээ. Эдгээрийн үр дүнд 2000 он болоход Төвдийн нийт малын тоо 23 сая толгойд хүрчээ. Үүнд сарлаг 4 сая толгой, шар үхэр 980 000, хайнаг 270 000, үнээ 1.55 сая, адуу 140 000, хонь 11.4 сая, ямаа 5.77 сая толгой байв. Махны үйлдвэрлэл 149 300 т, сүүн бүтээгдэхүүн 204 000 т., хонины ноос 8 609 т. тус тус хүрэв. 2008 онд Төвдөд бүх төрлийн мал 24 сая толгой болсон бол 1951 онд нийт тоо толгой нь 10 сая хүрэхгүй байжээ<sup>21</sup>. 2008 онд Төвдийн мал аж ахуйн өртөг 3,896,000,000 юань болж, 1959 оныхоос 5,1 дахин өсчээ. Махны нийт үйлдвэрлэл 242 700 тн, сүүн бүтээгдэхүүн 295 200 тн болжээ.

*Хөх-нуур:* Газарзүйн хувьд –Хөх-нуур нь Төвдийн өндөрлөгийн зүүн хойд хэсэгт далайн түвшнээс дээш 3000 м-ээс дээш өргөгдсөн. Нууруудын орчим нутаг далайн түвшнээс 3200-3600 м өндөрт өргөгдсөн сэрүүн нутаг бөгөөд 4-р сард ногоо цухуйж, 8-р сард цас

хаялах эрс тэс цаг ууртай.

Хөх нуурын район бол эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан. Энэхүү өндөрлөг нутаг давс их. Нэг тэмээнд 300, нэг сарлаганд 200 жин давс ачдаг байна. Хөх нуурын хошуу, шан бүр өвөрмөц. Давсан хошуу, давс их олборлох тул тэнд тэмээ нь сүргийн бүтцэд бусад хошууг бодвол илүү байдаг. Мал аж ахуйг механикжуулах асуудал их шаардлагатай. Адууг малын уналагад ихэвчлэн хэрэглэх авч, хааяа БНХАУ-ын төв хэсэгт худалдаалах явдал бас бий. Зарим нутагт хүн амын 90% нь ч мал аж ахуй эрхлэх байдал зонхилж байдаг. Одоо дунджаар өрх бүр 140, баян өрхөд 714 мал ноогдож байна.

Харин сүүлийн жилүүдэд бэлчээрийг нилээд суурьшилтай ашиглах болсон байна. Малчин өрх бүр төвлөрсөн бэлчээрийг зөв ашиглахын зэрэгцээ тэжээл, тариаланг хавсарга болгон эрхэлж байна.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

- <sup>1</sup> <http://www.nationsynceleopedia.com./Asia and Oceania/Uzbekistan-avim...3/15/2007>
- <sup>2</sup> Батцэцэг.Ч.,ОХУ-ын БНБуриадын Улс.УБ., 1996.т.34
- <sup>3</sup> Тува за 80 лет. Кызыл.2001. с.,11
- <sup>4</sup> мөн тэнд.с.14
- <sup>5</sup> мөн тэнд. с.28
- <sup>6</sup> мөн тэнд.с.53
- <sup>7</sup> мөн тэнд с.55
- <sup>8</sup> ОУС.2005.№4.,т.130
- <sup>9</sup> Өвөр монголын мал аж ахуй/1984-1993/ №5
- <sup>10</sup> Манай улсын мал аж ахуйн эхбаялаг хийгээд орон хуваариал. Хөх хот.1987.т.155
- <sup>11</sup> Өвөрмонголынмал аж ахуйн тойм.Хөххот.1991.т.114
- <sup>12</sup> М.Хасбагана.Мал аж ахуйн хамаралт. Шилийн гол.1988. т.116
- <sup>13</sup> “Өнөөгийн Хятад”, УБ., 2007.№1.,т.17
- <sup>14</sup> ОУС.2004.№3.т.102-115
- <sup>15</sup> The kazakhs of Chinaessays on an EthnicMinority6 Linda Benson and Ingvar Svanberg.p81
- <sup>16</sup> Синьцзян Китая. Изд-во.Чжоу Гуанбао. 1999,т.42
- <sup>17</sup> БНХАУ –ын үндэстний районууд дахь маогийнхны бодлого. УБ.,1978.т.60
- <sup>18</sup> Миньцзу Яньцзю 1982.№2.т.6-12



<sup>19</sup> Современный Синьцзян и его место в Казахстанских и Китайских отношениях.А.,1977. с.121

<sup>20</sup> Современный Синьцзян и его место в Казахстанских и Китайских отношениях.А.,1977. с.121

<sup>21</sup> “Хятад: Синьцзяны бодит байдал, тоо баримт-2009. Бээжин. 2009. 72-р тал

<sup>22</sup> “Төвд: Эдийн засаг, нийгэмийн хөгжилийн илтгэл”, Бээжин 2009. т.13